

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/225//НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:  
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99900662 Цахим хаяг:  
tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг:  
gansukhsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
ХӨВСГӨЛ АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Г.БАЗАР ТАНАА .....	4
Асуудлыг онцолсон хэсэг .....	4
.Аудитын гол асуудал .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	8
3.4 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	9
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
4.1 Ерөнхий зүйл .....	12
4.2 Материаллаг байдал .....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
4.5.1 Завсрын аудитын талаар .....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	13
5.1 Төлбөрийн акт .....	13
5.2 Албан шаардлага .....	13
5.3 Зөвлөмж.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	15

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар

## **1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

### **ХӨВСГӨЛ АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Г.БАЗАР ТАНАА**

#### **Хараат бус аудиторын дүгнэлт**

##### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

##### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### **Асуудлыг онцолсон хэсэг**

Төсвийн төлөвлөлтийг 7,191,749.8 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэл 5,061,905.7 мянган төгрөг буюу 70.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

##### **.Аудитын гол асуудал**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөлт, гүйцэтгэлийг уялдаатай, ойлгомжтой байдлаар тайлагнаагүй байна.

##### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 3 хөтөлбөр 93 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, үйл ажиллагааны хэрэгжилтийг хараахан гаргаагүй байна

##### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

##### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгрөгөөр/
			Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,912,175,973.95</b>	<b>2,145,097,717.88</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	2,180,381,907.95	1,291,374,966.07
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	2,180,381,907.95	1,291,374,966.07
<b>31211</b>	<b>Төрийн сангийн харилцах данс</b>	2,180,381,907.95	1,291,374,966.07
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	272,395,000	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	272,395,000	00.00
3351	Байгууллагаас авах авлага	272,395,000	00.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	459,399,066.00	853,722,751.81
36700	Бусад эргэлтийн хөрөнгө	459,399,066.00	853,722,751.81
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,912,175,973.95</b>	<b>2,145,097,717.88</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>75,150,223.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	75,150,223.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	75,150,223.00	00.00
4136	Бусад өглөг	75,150,223.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	75,150,223.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,837,025,750.95</b>	<b>2,145,097,717.88</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,837,025,750.95	2,145,097,717.88
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,837,025,750.95	2,145,097,717.88
	Өмнөх үеийн үр дүн	352,335,880.95	2,837,025,750.95
51220	Тайлант үеийн үр дүн	2,484,689,870.00	-691,928,033.07
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,912,175,973.95</b>	<b>2,145,097,717.88</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>6,100,491,416.00</b>	<b>4,369,977,693.93</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>6,100,491,416.00</b>	<b>4,369,977,693.93</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	5,875,491,416.00	4,369,977,693.93
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	5,875,491,416.00	4,369,977,693.93
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	225,000,000.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	225,000,000.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,538,988,038.00</b>	<b>5,061,905,727.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,538,988,038.00</b>	<b>5,061,905,727.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,538,988,038.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	505,404,738.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	505,404,738.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,033,583,300.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,033,583,300.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	00.00	5,061,905,727.00
<b>2132</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	00.00	5,061,905,727.00
213204	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	5,061,905,727.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>4,561,503,378.00</b>	<b>-691,928,033.07</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	2,076,813,508.00	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,076,813,508.00	00.00
<b>6</b>	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>2,484,689,870.00</b>	<b>-691,928,033.07</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>6,105,491,416.00</b>	<b>4,172,898,785.12</b>

Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,000,000.00	4,312,877.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,000,000.00	4,312,877.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,000,000.00	4,312,877.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	4,312,877.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,100,491,416.00	4,168,585,908.12
1311	Улсын төвлөрсөн төсвөөс	5,875,491,416.00	4,168,585,908.12
131101	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	5,875,491,416.00	4,168,585,908.12
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	225,000,000.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	225,000,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	728,404,738.00	5,061,905,727.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	728,404,738.00	5,061,905,727.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	728,404,738.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	503,404,738.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	503,404,738.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	225,000,000.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	225,000,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,061,905,727.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		5,061,905,727.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		5,061,905,727.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,377,086,678.00	-889,006,941.88
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,198,330,973.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,198,330,973.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	3,198,330,973.00	
223001	Бусад хөрөнгө	3,198,330,973.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	3,198,330,973.00	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,178,755,705.00	-889,006,941.88
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,626,202.95	2,180,381,907.95
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,180,381,907.95	1,291,374,966.07

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			352,335,880.95	352,335,880.95
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			352,335,880.95	352,335,880.95
C07	Тайлант үеийн үр дүн			2,484,689,870.00	2,484,689,870.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			2,837,025,750.95	2,837,025,750.95
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			2,837,025,750.95	2,837,025,750.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			2,837,025,750.95	2,837,025,750.95
D08	Тайлант үеийн үр дүн			-691,928,033.07	-691,928,033.07
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			2,145,097,717.88	2,145,097,717.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛАНТ ОНЫ		ЗӨРҮҮ	
	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,191,749,800	5,061,905,727	2,129,844,073	70.4
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	7,191,749,800	5,061,905,727	2,129,844,073	70.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,191,749,800	5,061,905,727	2,129,844,073	70.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	7,191,749,800	5,061,905,727	2,129,844,073	70.4
Засгийн газрын дотоод шилжүүлэг	7,191,749,800	5,061,905,727	2,129,844,073	70.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,191,749,800	4,172,898,785	3,018,851,015	58.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,148,742,900	4,168,585,908	-19,843,008	100.5
Улсын төвлөрсөн төсвөөс				
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	4,148,742,900	4,168,585,908	-19,843,008	
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
Орон нутгийн төсвөөс				
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,043,006,900	4,312,877	3,038,694,023	0.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,312,877	-4,312,877	
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,043,006,900		3,043,006,900	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	2,180,381,908		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	1,291,374,966		

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:** Орон нутгийн хөгжлийн сангийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг баримтлан ажиллаж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Орон нутгийн хөгжлийн сангийн дотоод хяналтын үүргийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба гүйцэтгэдэг. Тайлант онд хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын нэг, хоёрдугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 767,078.3 мянган төгрөгөөр буюу 26.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,180,381.9	1,291,375.0	(889,006.9)
Авлага	272,395.0	-	(272,395.0)
Бусад эргэлтийн хөрөнгө	459,399.1	853,722.8	394,323.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,912,176.0</b>	<b>2,145,097.7</b>	<b>(767,078.3)</b>
Өр төлбөр	75,150.2	-	(75,150.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,837,025.8	2,145,097.7	(691,928.0)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,912,176.0</b>	<b>2,145,097.7</b>	<b>(767,078.3)</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,291,375.0 мянган төгрөг болж өмнөх оноос 889,006.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх онд 272,395.0 мянган төгрөг байсныг барагдуулж тайлант онд үлдэгдэлгүй байна.

Бусад үндсэн хөрөнгө 853,722.8 мянган төгрөг болж өмнөх оноос 394,323.7 мянган төгрөгөөр өссөн нь он дамжсан хөрөнгө оруулалт болон улсын комисс хүлээж аваагүй төсөл, арга хэмжээ байгаатай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.0 төгрөг болж 75,150.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,145,097.7 мянган төгрөг болж, тайлант үеийн үр дүн 691,928.0 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 1.3 дугаар заалтын дагуу Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн

санд олгох орлогын шилжүүлгийг Сангийн яамнаас тооцон аймаг, нийслэлүүдэд хуваарилж байна. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилагдсан хөрөнгийг аймаг, сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Орон нутгийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ыг баримталж хуваарилалтыг хийсэн байна.

Тайлант онд Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 6,467,366.8 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 4,548,930.0 урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 1,248,516.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 669,920.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 6 дүгээр сарын 22-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх баталсан төсвийг 724,383.0 мянган төгрөгөөр бууруулж 7,191,749.8 мянган төгрөгийн төсөв баталж Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 4,187,610.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 901,492.1 мянган төгрөг, мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 2,102,647.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр тодотгосон байна. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөлтөд төсвийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих дүнг 38,867.1 мянган төгрөгөөр бага, урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 38,867.1 мянган төгрөгөөр их дүнгээр үзүүлэлт хооронд гүйлгэж алдаатай төлөвлөсөн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 4,168,585.9 мянган төгрөгийн санхүүжилт, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 889,006.9 мянган төгрөгөөр санхүүжилт бүрдүүлж, нийт урсгал үйл ажиллагаанд 5,057,592.9 мянган төгрөгийн гүйцэтгэл гарч 1,291,374.9 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй гарсан байна.

Төсвийн нийт зардал 5,061,905.7 мянган төгрөг, үүнээс орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зардал 4,561,705.7 мянган төгрөг, мал эмнэлгийн үйлчилгээний зардал 500,200.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Тухайн байгууллагын төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр харуулбал:

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээгээр

№	Хөтөлбөрийн код, нэр	Зардлын дүн		/мянган.төгрөгөөр/	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биел элт
1	70501 ОН-ын төсөвт олгох шилжүүлэг	0	0	0	0
2	70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	6,691,549.8	4,561,705.7	2,129,844.1	68.2
3	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	500,200.0	500,200.0	0.00	100
<b>Нийт дүн</b>		<b>7,191,749.8</b>	<b>5,061,905.7</b>	<b>2,129,844.1</b>	<b>68.2</b>

Тайлант онд 7,191,749.8 мянган төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, нийт урсгал үйл ажиллагаанд 5,061,905.7 мянган төгрөгийн гүйцэтгэл гарч 1,291,374.9 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн сан нь нэмэлт санхүүжилтийн дансгүй.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 8/157 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2 хувиар тогтоож үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 3,769,788.7 мянган төгрөгөөс тооцож 56,546.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 45,237.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагын тайлант онд төсөвлөсөн төсөл арга хэмжээнээс нэр шаардлагатай бус 361,320.0 мянган төгрөгийн 9 төсөл арга хэмжээний төсвийн тодотголоор хассан байна.

Тус байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлсэн. Горим сорилыг хэрэгжүүлэх явцад төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь 30,785.4 мянган төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцрон оруулж, бусад мэдээллийг хугацаанд нь мэдээлж ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хянаж үзэхэд зөвлөмжийн хэрэгжилтийг биелүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	3,012,200.0	1	3,012,200.0	100
Нийт дүн	2	3,012,200.0	2	3,012,200.0	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалттай холбоотой асуудал байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 43,180.0 мянган төгрөгийн 3 алдааг илрүүлж зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Төсвийн

###### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулж байх.

##### 1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөлтөд төсвийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих дүнг батлагдсан төсвөөс 38,867.1 мянган төгрөгөөр бага, урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 38,867.1 мянган төгрөгөөр их дүнгээр үзүүлэлт хооронд гүйлгэж алдаатай тайлагнасан байна. Энэ нь Хөвсгөл аймгийн ИТХ-аас баталсан 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 5 дугаар тогтоол "Аймгийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, 2022 оны төсөв батлах тухай", 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 10 дугаар тогтоол "Аймгийн 2022 оны төсөвт тодотго хийх тухай"-той нийцэхгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг батлагдсан төсвийн дагуу тайлагнаж байх

## **2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

### **Илрүүлэлт:**

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 4,312.9 мянган төгрөгийн орлогын залруулгын гүйлгээг өөрийн орлого гэж тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.2 “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах” заалттай нийцэхгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Төсвийн гүйцэтгэлийн орлого, зардлыг цэвэр дүнгээр тайлагнаж байх

## **3. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

### **Илрүүлэлт:**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөлт, гүйцэтгэлийг уялдаатай тайлагнаагүй байна. Энэ нь УСНББОУС 24 Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээлэл Параграф 31 “Төсвийн ба гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох бүх зэрэгцүүлэлтийг тухай төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар толилуулна”-тэй нийцэхгүй байна

### **Өгсөн зөвлөмж:**

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төлөвлөгөө, гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэх боломжтой байдлаар тайлагнаж байх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөлтөд төсвийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих дүнг 38,867.1 мянган төгрөгөөр бага, урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 38,867.1 мянган төгрөгөөр их дүнгээр үзүүлэлт хооронд гүйлгэж алдаатай тайлагнасан байна.	1	38,867.1	0	0	0	0	0	0	1	38,867.1	1	38,867.1
Төсвийн гүйцэтгэлийн тайланд 4,312.9 мянган төгрөгийн орлогын залруулгын гүйлгээг өөрийн орлого гэж тайлагнасан байна.	1	4,312.9							1	4,312.9	1	4,312.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөлт, гүйцэтгэлийг уялдаатай тайлагнаагүй байна	1								1		1	
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>43,180.0</b>							<b>3</b>	<b>43,180.0</b>	<b>3</b>	<b>43,180.0</b>

### АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

С.ГАНСҮХ ОГНОО: